



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 9/68

Дархан

“ДДС” ТӨХК-ийн орлогын байцаагчдын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох тусгай журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, “ДДС” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалт, “ДДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “ДДС” ТӨХК-ийн орлогын байцаагчдын ажлыг дүгнэх, авлага барагдуулах чиглэлээр сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох тусгай журам-г хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү борлуулалтын хэлтсийн Гэрээ борлуулалтын хэсгийн дарга (Ё.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАТЖАРГАЛ

452501243





“ДДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын  
2025 оны 04 дүгээр сарын 02 өдрийн  
а/68 тоот тушаалын хавсралт

**ОРЛОГЫН БАЙЦААГЧДЫН АЖЛЫГ ДҮГНЭХ, АВЛАГА БАРАГДУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР  
САРЫН ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ТУСГАЙ ЖУРАМ**

“ДДС” ТӨХК-ийн Санхүү борлуулалтын хэлтсийн Гэрээ, борлуулалтын хэсгийн орлогын байцаагчдын ажлыг дүгнэх, сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Энэхүү журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн 2.4, 2.5, 103, 108, 109 дүгээр зүйл, Эрчим хүчний салбарын /тарифын/ хэлэлцээрийн 3.8, Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээний 3.5 заалт, “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудад сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.13 заалтыг тус тус үндэслэн боловсруулав.

**Нэг. Журмын зорилго:**

1.1. Энэхүү журмын зорилго нь: “ДДС” ТӨХК-ийн борлуулалтын орлогын төлөвлөгөөг 100% биелүүлэх, орлого цуглуулалтыг нэмэгдүүлж авлагын үлдэгдлийг бууруулах, компанийн зорилтот түвшнийг ханган биелүүлж, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, борлуулалтын орлогын байцаагчдыг ажлын гүйцэтгэлээр нь дүгнэж, эцсийн үр дүнгээр нь цалин, нэмэгдэл хөлс олгож, идэвхжүүлэхэд оршино.

**Хоёр. Ажилтны ажлыг дүгнэх, цалин шагнал,  
нэмэлт урамшуулал олгох**

2.1. Орлогын байцаагчдын үндсэн цалин нь тухайн жилийн “ДДС” ТӨХК-д мөрдөгдөж байгаа цалингийн батлагдсан жишгийн дээд, доод шатлалаар байна.  
(2025 онд доод шатлал 1.432.000 төгрөг , дээд шатлал 1.617.000 төгрөг байна)

Үндсэн үзүүлэлт	Цалингийн зэрэглэл		I	II
	Үндсэн цалин		Доод шатлал	Дээд шатлал
	Борлуулалтын орлого цуглуулалтын %	Халаалтын улиралд / 9 - 5-р сар /		100 % хүрээгүй
Халаалтын бус улиралд / 6-8-р сар /		100 % хүрээгүй	100%, түүнээс-дээш	

2.2. Орлогын байцаагч нарын сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс тооцох дээд хэмжээ нь “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудад сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.2, 2.11 заалтын дагуу байна.

2.3. Орлогын байцаагч нарын сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг цалин дүгнэх 6 үзүүлэлт тус бүрийг үндэслэн компанийн тухайн сарын батлагдсан хувиас тооцон хувиалан дүгнэж олгоно.



№	Үзүүлэлт	Халаалтын улиралд			Халаалтын бус улиралд		
		100% хүрэхгүй	100%, - 104,99%	105%, түүнээс дээш хувь	100% хүрэхгүй	100%-120,99%	121%, түүнээс дээш хувь
	Цалингийн шатлал	Доод шатлал	Дээд шатлал		Доод шатлал	Дээд шатлал	
1	Борлуулалтын авлага барагдуулалт %-аар /тухайн сар/	100%-иас доош оруулсан 1% тутамд 2 оноо хасна.	25 хүртэл оноо	25 хүртэл оноо	100%-иас доош оруулсан 1% тутамд 2 оноо хасна.	25 хүртэл оноо	25 хүртэл оноо
2	Оны эхний авлага барагдуулалт, /өссөн дүнгээр/	0	0	СҮДНХ тооцох дээд хэмжээ 50% ба тухайн сарын батлагдсан хувийн зөрүү	0	0	СҮДНХ олгох дээд хэмжээ 50% ба тухайн сарын батлагдсан хувийн зөрүү
3	Тоолуурын заалт авалт /зоорийн давхар хамаарна./	5 хүртэл оноо					
4	Ажлын цаг ашиглалт, компани, албанаас зохиосон ажилд оролцсон байдал	5 хүртэл оноо					
5	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт, хөдөлмөрийн сахилга бат	5 хүртэл оноо					
6	Хэрэглэгчээс ирсэн гомдол, санал	5 хүртэл оноо					

2.3. Орлогын байцаагчид нь 100%-иас доош авлагыг барагдуулсан тохиолдолд тухайн сарын батлагдсан хувиас /оноотой дүйцнэ гэж үзнэ/ цалин дүгнэх хүснэгтийн 3,4,5,6-р үзүүлэлтийн нийлбэрийг / 20 оноо/ хасч, үлдсэн оноог 100%-иас доош оруулсан 1% тутамд 2 оноог хасч тооцно.

2.4. Орлогын байцаагчид нь 100%-104,99% авлагыг барагдуулсан бол компанийн тухайн сарын батлагдсан хувиас /оноотой дүйцнэ гэж үзнэ/ цалин дүгнэх хүснэгтийн 3,4,5,6-р үзүүлэлтийн нийлбэрийг хассан /20оноо/ оноогоор дүгнэгдэнэ.

2.5. Орлогын байцаагч нар нь "Оны эхний авлага барагдуулалтад санаачилсан ажил, үр дүн /өссөн дүнгээр/" гэсэн үзүүлэлтийг халаалтын улиралд 105%-иас, халаалтын бус улиралд 121% - иас дээш тус тус биелүүлсэн тохиолдолд СҮДНХ тооцох 50% ба компанийн тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохоор батлагдсан хувийн зөрүүг сар бүр олгоно. Компанийн тухайн сарын батлагдсан хувь 50 гарсан тохиолдолд зөрүү хувийг тооцох боломжгүй болно.

2.6. Компанийн тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тооцох хувь 50%-иар батлагдсан тохиолдолд орлогын байцаагчид нь "Борлуулалтын авлага барагдуулалт %-аар /тухайн сар/" үзүүлэлтийг 100%-иас дээш биелүүлсэн бол 30 хүртэл оноогоор дүгнэнэ.

### Гурав. Нэмэгдэл урамшуулал олгох

3.1. Орлогын байцаагчид нь найдваргүй авлагын хасагдуулгад орсон хэрэглэгчийн төлбөрийн үлдэгдлийг төлүүлж, компанид нэмэлт орлого оруулсан тохиолдолд " ДДС" ТӨХК-ийн ажилтанд урамшуулал олгох" журамд заасны дагуу оруулсан орлогоос 20 хүртэл хувийн урамшуулал олгоно.

3.2. Орлогын байцаагчид нь хэрэглэгчидийн гэрээний үзүүлэлтийг баталгаажуулан нэмэгдүүлж тооцоонд оруулж, компанийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан тохиолдолд дараах жишгээр урамшуулал олгоно.



<b>Нэмэлт үзүүлэлт</b>	<b>Дулааны төлбөр тооцох гэрээний үзүүлэлтийг бодитоор нэмж баталгаажуулсан үзүүлэлт</b>	<b>1 оршин суугч</b>	<b>1м<sup>2</sup> талбай</b>	<b>1м<sup>3</sup> эзэлхүүн</b>	<b>1 тн ус</b>	<b>1 Гкал дулаан</b>	<b>Шинэ хэрэглэгч</b>
		<b>Олгох урамшуулал 7-өөр</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>500</b>	<b>500</b>	<b>500</b>

3.3. Борлуулалтын орлогын байцаагч нь зөвшөөрөлгүй дулааны эрчим хүч хэрэглэсэн, дулаан тооцох талбай болон ХХУ-ны цоргыг дур мэдэн өөрчилсөн, ХХУ-ны тоолуурыг санаатайгаар гэмтээсэн, механик эд ангийг зогсоох үйлдлийг хийсэн, талбай нэмэгдүүлснээ нуун дарагдуулсныг илрүүлэн гэрээний үзүүлэлтэд нэмэгдүүлсэн, зүй бус хэрэглээг илрүүлсэн тохиолдолд тухайн оруулсан орлогын 20 хувиар нэмэгдэл олгоно.

3.4. Урамшууллыг хэрэглэгчтэй байгуулах аж ахуйн гэрээний үзүүлэлт баталгаажин, тооцоонд оруулж, нэхэмжлэгдэн, төлөгдсөн бол төлбөр орсон сард нь 1 удаа олгоно.

### **Дөрөв. Хариуцлага тооцох**

4.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд "Хөдөлмөрийн тухай хууль", компанийн "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

### **Тав. Дүгнэх**

5.1. Борлуулалтын ахлах мэргэжилтэн нь сар бүр байцаагч нарын орлогын төлөвлөгөөний биелэлт, авлагын бууралтыг тооцож дүгнэх, цалин, нэмэгдлийн тооцоог байцаагч нэг бүрээр гаргасан бүртгэл тооцоо, судалгаатай байх ба энэхүү судалгаа тооцоог үндэслэж сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгох саналыг боловсруулан хэсгийн даргад гаргаж өгнө.

5.2. Хэсгийн дарга нь орлогын байцаагчдыг журмын дагуу үнэн зөв тодорхойлж комисст оруулж баталгаажуулж цалин хөлс, нэмэгдэл хөлсийг тооцож олгуулна.

